



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Хүүхдийн 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БӨА-2026/078/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2026 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
23 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ А.АЙЖАН ТАНАА

2026.02.25 № 142

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өлгий сумын хүүхдийн 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өлгий сумын Хүүхдийн 23 дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,255.6 мянган төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,225.7 мянган төгрөг зарцуулж, 97.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832605000245

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>205,237,856.65</u> | <u>97,047,643.01</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 161,704,464.76 | 35,718,487.34 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 161,704,464.76 | 35,718,487.34 |
| 3121 | Төгрөг | 161,704,464.76 | 35,718,487.34 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 161,704,464.76 | 35,718,487.34 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,533,391.89 | 61,329,155.67 |
| 354 | Хангамжийн материал | 43,533,391.89 | 61,329,155.67 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 380,000.00 | 1,758,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 600,000.00 | 600,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 9,067,916.67 |
| 35460 | Хүнсний материал | 190,203.89 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 42,363,188.00 | 49,903,239.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>41,530,701.08</u> | <u>30,024,688.98</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 41,530,701.08 | 30,024,688.98 |
| 392 | Биет хөрөнгө | 39,848,992.48 | 28,891,628.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,653,333.00 | 1,653,333.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (120,555.54) | (327,222.18) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,723,476.40 | 40,922,076.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (13,699,298.13) | (22,606,852.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,283,885.00 | 18,803,885.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,991,848.25) | (9,553,591.95) |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,681,708.60 | 1,133,060.80 |
| 39301 | Програм хангамж | 2,743,239.00 | 2,743,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,061,530.40) | (1,610,178.20) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>246,768,557.73</u> | <u>127,072,331.99</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>300.00</u> | <u>5,307,865.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 300.00 | 5,307,865.00 |
| 413 | Өглөг | 300.00 | 5,307,865.00 |
| 4136 | Бусад өглөг | 300.00 | 5,307,865.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 300.00 | 113,165.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 5,194,700.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>246,768,257.73</u> | <u>121,764,466.99</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 246,768,257.73 | 121,764,466.99 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 246,768,257.73 | 121,764,466.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 246,768,257.73 | 246,768,257.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (125,003,790.74) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>246,768,557.73</u> | <u>127,072,331.99</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 917,352,242.00 | 1,110,974,600.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 917,352,242.00 | 1,110,974,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 848,106,542.00 | 978,474,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,694,300.00 | 978,474,400.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 15,564,433.00 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал | 9,847,809.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,245,700.00 | 132,500,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,245,700.00 | 132,500,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 921,034,080.32 | 1,235,978,390.74 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 921,034,080.32 | 1,235,978,390.74 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 920,387,424.32 | 1,224,748,316.74 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 641,878,833.30 | 876,092,111.42 |
| 210101 | Үндсэн цалин | 451,796,023.01 | 584,965,077.61 |
| 210102 | Нэмэгдэл | 162,412,228.39 | 241,024,176.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 21,457,004.60 |
| 210104 | Урамшуулал | 27,670,581.90 | 28,645,852.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 85,465,538.47 | 103,239,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,993,038.68 | 70,208,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,481,485.26 | 8,260,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,510,900.00 | 4,131,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,510,900.00 | 4,131,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,969,214.53 | 16,507,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 64,606,044.00 | 109,987,759.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,799,044.00 | 6,588,926.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,582,000.00 | 15,932,083.33 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,225,000.00 | 666,750.00 |
| 210304 | Байрны түрээс | 47,000,000.00 | 86,800,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 92,863,064.11 | 99,673,334.89 |
| 210502 | Хоол, хүнс | 92,863,064.11 | 99,673,334.89 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,610,000.00 | 1,187,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,610,000.00 | 1,187,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,305,600.00 | 3,349,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,305,600.00 | 3,349,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,658,344.44 | 31,219,061.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,537,310.00 | 12,378,149.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,911,000.00 | 5,616,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,210,034.44 | 13,224,612.10 |

Өлгий сумын Хүүхдийн 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|--|-----------------------|-------------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 646,656.00 | 11,230,074.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 646,656.00 | 11,230,074.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 646,656.00 | 11,230,074.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>(3,681,838.32)</u> | <u>(125,003,790.74)</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>(3,681,838.32)</u> | <u>(125,003,790.74)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>891,940,000.00</u> | <u>1,110,974,600.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 891,940,000.00 | 1,110,974,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 822,694,300.00 | 978,474,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,694,300.00 | 978,474,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,245,700.00 | 132,500,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,245,700.00 | 132,500,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>914,433,669.77</u> | <u>1,236,960,577.42</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 914,056,669.77 | 1,235,241,977.42 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 913,410,013.77 | 1,224,011,903.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 645,607,129.30 | 876,092,111.42 |
| 210101 | Үндсэн цалин | 454,897,994.52 | 584,965,077.61 |
| 210102 | Нэмэгдэл | 163,038,552.88 | 241,024,176.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 21,457,004.60 |
| 210104 | Урамшуулал | 27,670,581.90 | 28,645,852.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 81,737,242.47 | 103,239,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,039,711.21 | 70,208,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,481,485.26 | 8,260,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,510,900.00 | 4,131,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,510,900.00 | 4,131,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,194,246.00 | 16,507,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,949,044.00 | 120,110,376.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,799,044.00 | 6,588,926.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,000,000.00 | 25,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,150,000.00 | 1,721,450.00 |
| 210304 | Байрны түрээс | 47,000,000.00 | 86,800,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 90,682,998.00 | 94,175,466.00 |
| 210502 | Хоол, хүнс | 90,682,998.00 | 94,175,466.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,650,000.00 | 1,159,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,650,000.00 | 1,159,750.00 |

Өлгий сумын Хүүхдийн 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|--|-----------------|------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,305,600.00 | 3,349,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,305,600.00 | 3,349,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,478,000.00 | 25,885,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,042,000.00 | 17,484,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,436,000.00 | 8,401,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 646,656.00 | 11,230,074.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 646,656.00 | 11,230,074.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 646,656.00 | 11,230,074.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (22,116,669.77) | (125,985,977.42) |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 377,000.00 | 1,718,600.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 377,000.00 | 1,718,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 377,000.00 | 1,718,600.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (377,000.00) | (1,718,600.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (22,493,669.77) | (125,985,977.42) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 184,198,134.53 | 161,704,464.76 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 161,704,464.76 | 35,718,487.34 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|-------------------|--|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 250,450,096.05 | 250,450,096.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 250,450,096.05 | 250,450,096.05 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | (3,681,838.32) | (3,681,838.32) |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 246,768,257.73 | 246,768,257.73 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 246,768,257.73 | 246,768,257.73 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 246,768,257.73 | 246,768,257.73 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | (125,003,790.74) | (125,003,790.74) |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 121,764,466.99 | 121,764,466.99 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-------------------------|-------------------------|----------------------|--------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,255,458,400.00 | 1,225,730,503.42 | 29,727,896.58 | 97.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,255,458,400.00 | 1,225,730,503.42 | 29,727,896.58 | 97.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,255,458,400.00 | 1,225,730,503.42 | 29,727,896.58 | 97.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 884,636,700.00 | 876,092,111.42 | 8,544,588.58 | 99.0 |
| 210101 | Үндсэн цалин | 593,669,100.00 | 584,965,077.61 | 8,704,022.39 | 98.5 |
| 210102 | Нэмэгдэл | 264,371,300.00 | 241,024,176.61 | 23,347,123.39 | 91.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 21,457,004.60 | (21,457,004.60) | - |
| 210104 | Урамшуулал | 26,596,300.00 | 28,645,852.60 | (2,049,552.60) | 107.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 109,803,300.00 | 103,239,400.00 | 6,563,900.00 | 94.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,502,200.00 | 70,208,600.00 | 4,293,600.00 | 94.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,825,200.00 | 8,260,300.00 | 564,900.00 | 93.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,412,700.00 | 4,131,600.00 | 281,100.00 | 93.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,412,700.00 | 4,131,600.00 | 281,100.00 | 93.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,650,500.00 | 16,507,300.00 | 1,143,200.00 | 93.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 131,300,200.00 | 120,110,376.00 | 11,189,824.00 | 91.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,169,000.00 | 6,588,926.00 | 1,580,074.00 | 80.7 |
| 210302 | Түлш, халаалт | 25,000,000.00 | 25,000,000.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,131,200.00 | 1,721,450.00 | 409,750.00 | 80.8 |
| 210304 | Байрны түрээс | 96,000,000.00 | 86,800,000.00 | 9,200,000.00 | 90.4 |
| 2105 | Нормативт зардал | 95,064,200.00 | 94,175,466.00 | 888,734.00 | 99.1 |
| 210502 | Хоол, хүнс | 95,064,200.00 | 94,175,466.00 | 888,734.00 | 99.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,200,000.00 | 1,159,750.00 | 40,250.00 | 96.6 |
| 210604 | Урсгал засвар | 1,200,000.00 | 1,159,750.00 | 40,250.00 | 96.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,547,800.00 | 4,547,800.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,547,800.00 | 4,547,800.00 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,906,200.00 | 26,405,600.00 | 2,500,600.00 | 91.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,504,400.00 | 18,004,000.00 | 2,500,400.00 | 87.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,401,800.00 | 8,401,600.00 | 200.00 | 100.0 |

Өлгий сумын Хүүхдийн 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|--|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,255,458,400.00 | 1,099,744,526.00 | 155,713,874.00 | 87.6 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 979,013,100.00 | 978,124,400.00 | 888,700.00 | 99.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 979,013,100.00 | 978,124,400.00 | 888,700.00 | 99.9 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 132,500,200.00 | 121,270,126.00 | 11,230,074.00 | 91.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 132,500,200.00 | 121,270,126.00 | 11,230,074.00 | 91.5 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 143,945,100.00 | 350,000.00 | 143,595,100.00 | 0.2 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 350,000.00 | (350,000.00) | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 143,945,100.00 | - | 143,945,100.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 161,704,464.76 | | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 35,718,487.34 | | - |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 40 | 40 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21 | 21 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18 | 18 | - | 100.0 |

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 641.9 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 641.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөг

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|--------------|---------------|--------------|-----------------|----------|----------|-----|--------------------------------------|----------|---|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл оногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад нэр бүхий 2 ажилтанд 641.9 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна. | 1 | 641.9 | 1 | 641.9 | - | - | - | - | - | - | - | - |
| Харилцагчидтай байгуулсан гэрээнд нийлүүлэх барааны нэр төрөл, үнийг тодорхой тусгаагүй байна. | 1 | | - | - | - | - | 1 | | - | - | - | - |
| ДҮН | 2 | 641.9 | 1 | 641.9 | - | - | 1 | | - | - | - | - |